



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/877

Ховд

Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а” заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 74 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.4.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймагт хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхэлдэг хувь хүн, аж ахуй нэгжийн бүтээгдэхүүнийг сурталчлах, нэгдсэн сав баглаа боодолтой брэнд багцанд оруулах бүтээгдэхүүнийг шалгаруулах зорилгоор “Хаврын өнгө-2022” үзэсгэлэн худалдааг 2022 оны 01 дүгээр сарын 19-нээс 01 дүгээр сарын 28-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. “Хаврын өнгө -2022” үзэсгэлэн худалдааг сум, орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагууд болон иргэдийг өргөнөөр оролцуулан “Ковид-19” цар тахлын ариутгал халдваргүйжүүлэлтийн дэглэмийг баримтлан ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга: Т.Жаргалсайхан - Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Ц.Цогтбаяр - Жаргалант сумын Засаг дарга

Ш.Батжаргал - Шинэ Ховд Баруун бүсийн хөгжлийн корпораци Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга

Б.Бямбажав - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга


П.Эрдэнэчулуун - Мэргэжлийн хяналтын газрын дарга

Л.Билэгдэмбэрэл - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

- С.Ариунжаргал - Хөгжимт драмын театрын дарга
- Б.Пүрэвдорж - Хот тохижуулах газрын дарга
- Б.Баяржаргал - Зоонозын өвчин судлалын төвийн дарга
- Б.Гомбосүрэн - Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн дарга
- Д.Баярмаа - Хөгжил политехник коллежийн захирал
- Б.Ганзориг - Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга
- Г.Хүрэлмөнх - “Ховд Эвийн хүч” хоршооны дарга
- Д.Эрдэнэдорж - Хүнс, Хөдөө аж ахуйн газрын албаны дарга
- А.Арбол - Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга
- О.Дарьжав - Мэргэжлийн хяналтын улсын байцаагч
- Д.Манат - Хүнс, Хөдөө Аж Ахуйн газрын мэргэжилтэн
- Х.Энхмаа - Жаргалант сумын Хүнс жижиг дунд үйлдвэр, Хоршоо хариуцсан мэргэжилтэн
- Б.Уянгамаа - Шинэ Ховд Баруун бүсийн хөгжлийн корпораци Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нягтлан бодогч
- Х.Алтантуяа - Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан
- Нарийн бичгийн дарга: Ц.Лувсанлхамо - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтний албан үүргийн түр орлон гүйцэтгэгч

3. Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг өргөнөөр оролцуулан ажиллахыг ажлын хэсгийн дарга /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ